



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн "Дулаан шарын гол" ТӨХК-тйн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 220,3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг "Дулаан шарын гол" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Энхцэцэгт үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайландаа дурдсан зөрчил, дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

2.3. Авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, харилцагчидтай тооцоо нийлэн тодорхой хугацаанд төлбөрөө төлөх гэрээ байгуулан, хугацаа хожимдсон тохиолдолд алданги тооцох зэргээр харилцан тохиролцох, албан мэдэгдэл хүргүүлэх, шаардлагатай бол өр, авлага барагдуулах ажилд хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

2.4. 2017 оны жилийн эцсээр тоологдсон 367 толгой мал сүргийг зах зээлийн бодит үнэ цэнээр үнэлж, тайлан балансад тусган, НББОУС-ыг мөрдөж ажиллах,

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002921

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын  
газрын 2019 оны 07 дугаар сарын 08-ны  
өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
2	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль зөрчин худалдан авалт хийсэн	Захирал Б.Энхцэцэг Ерөнхий ня-бо Н.Даш	209.1	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 33.1, 33.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах
3	Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт зөрчиж биологийн хөрөнгийг зах зээлийн бодит үнэ цэнээс хэт доогуур үнэлж, санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан	Захирал Б.Энхцэцэг Ерөнхий ня-бо Н.Даш	11.20	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
	Дүн		220.3	